

Үндсэн сургаалууд

Үндсэн сургаалууд нь институт, семинарын ангиудад чухал ач холбогдолтой байдаг. Багш нар суралцагчдадаа сайн мэдээний эдгээр үндсэн сургаалуудыг таньж мэдэн, ойлгож, үүнд итгэж, үүнийг тайлбарлаж мөн амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах ёстой. Ингэснээр суралцагчдыг гэрчлэлээ хүчирхэгжүүлж, Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг үнэлэх үнэлэмжээ өсгөхөд нь тусалж чадна. Эдгээр сургаалуудаас суралцах нь суралцагчдыг энэ чухал үнэнүүдийг бусдад заахад илүү сайн бэлтгэгдсэн байхад нь тусалдаг.

Шашны институт ба семинарын төгс эзэмших 100 судрын ихэнхийг суралцагчдын үндсэн сургаалын ойлголтыг дэмжихийн тулд сонгосон. Энэ хэсэгт жагсаасан ихэнх тайлбарууд нь төгс эзэмших судруудтай хамаатай. Эдгээр нь үндсэн сургаалд хамааралтай эсэхийг харуулахын тулд тэдгээрийг багтаасан.

ЕСҮС ХРИСТИЙН

ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

1. Бурхан Тэргүүтэн

Бурхан Тэргүүтэнд гурван тусдаа хүмүүн биет байдаг: Бурхан, Мөнхийн Эцэг; Түүний Хүү, Есүс Христ; мөн Ариун Сүнс (Иосеф Смитийн —түүх 1:15–20-ийг үзнэ үү). Эцэг мөн Хүү хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой; харин Ариун Сүнс бол Сүнсэн хүн буюу (С ба Г 130:22–23-ыг үзнэ үү). Тэдгээрийн зорилго болон сургаал нь нэг юм. Тэд бол Тэнгэрлэг Эцэгийн гайхалтай авралын төлөвлөгөөг тохиолгон авчрахад төгс нэгдсэн нэгдэл билээ.

Бурхан Эцэг

Бурхан Эцэг бол ертөнцийн Хамгийн Дээд Захирагч. Тэр бол бидний сүнснүүдийн Эцэг (Еврей 12:9-ийг үзнэ үү). Тэр бол төгс, бүх хүч чадлыг эзэмшдэг, мөн бүх зүйлсийг мэддэг. Тэрээр төгс нигүүлсэл, нинжин сэтгэл ба энэрлийн Бурхан юм.

Есүс Христ

Есүс Христ бол Эцэгийн бие махбод дахь Цорын Ганц мөн сүнсэн дэх Эцэгийн Ууган Хүү. Тэр бол Хуучин Гэрээний Иехова мөн Шинэ Гэрээний Мессиа билээ.

Есүс Христ нүгэлгүй амьдралаар амьдарч бүх хүн төрөлхтний нүглийн төлөө төгс Цагаатгал хийсэн (Алма 7:11–13-ыг үзнэ үү). Түүний амьдрал бол бүх хүн төрөлхтөн хэрхэн амьдрах ёстойн төгс үлгэр жишээ юм (Иохан 14:6; 3 Нифай 12:48-ыг үзнэ үү). Тэрээр дэлхий дээр амилуулагдсан анхны хүн байлаа. (1 Коринт 15:20–22-ыг үзнэ үү). Есүс Христ хүч, алдар суундаа дахин ирж, Мянгэн жилийн турш дэлхий дээр хаанчлах болно.

Бүхий л залбирал, адислалууд болон санваарын ёслолууд Есүс Христийн нэр дээр гүйцэтгэгдэх ёстой (3 Нифай 18:15, 20–21-ийг үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Хиламан 5:12; С ба Г 19:23; С ба Г 76:22–24

Ариун Сүнс

Ариун Сүнс бол Бурхан Тэргүүтэний гуравдагч гишүүн юм. Тэрээр мах, ясан биегүй сүнсэн хүн. Түүнийг Сүнс, Ариун Сүнс, Бурханы Сүнс, Их Эзэний Сүнс, мөн Тайтгаруулагч гэж олонтоо нэрлэдэг.

Ариун Сүнс Эцэг, Хүү хоёрын тухай гэрчилж, бүх зүйлийн үнэнийг илчлэн, мөн наманчилж, баптисм хүртсэн хүмүүсийг ариусгадаг (Моронай 10:5-ыг үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Галат 5:22–23; С ба Г 8:2–3

2. Авралын Төлөвлөгөө

Мөнх бус байдлын өмнөх амьдралд, Тэнгэрлэг Эцэг биднийг Өөртэйгөө адилхан болгох, үхэшгүй байдал ба мөнх амьдралыг (Мосе 1:39-ийг үзнэ үү) хүлээн авах төлөвлөгөөг танилцуулсан. Судруудад энэ төлөвлөгөөг авралын төлөвлөгөө, аз жаргалын агуу төлөвлөгөө, гэтэлгэлийн төлөвлөгөө, нигүүлслийн төлөвлөгөө гэж нэрлэдэг.

Авралын төлөвлөгөөнд Бүтээлт, Уналт, Есүс Христийн Цагаатгал, түүнчлэн сайн мэдээний бүх хууль, ёслол, сургаалууд багтдаг. Ёс сонгох эрх буюу өөрсдийнхөө төлөө сонгож, үйлдэх чадвар нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд нэн чухал юм (2 Нифай 2:27-г үзнэ үү). Бид энэ төлөвлөгөөний ачаар Цагаатгалаар дамжин төгөлдөржин, баяр баясгалангийн бүрэн дүүрнийг хүлээн авч, Бурханы оршихуйд үүрд мөнх амьдарч чадна (3 Нифай 12:48-ыг үзнэ үү). Гэр бүлүүд үүрд мөнхөд байж чадна.

Холбогдох эшлэлүүд: Иохан 17:3; С ба Г 58:27

Мөнх бус байдлын өмнөх амьдрал

Бид дэлхийд төрөхөөсөө өмнө Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүдийн хувьд Түүний оршихуйд амьдарч байжээ (Абрахам 3:22–23-ыг үзнэ үү). Мөнх бус байдлын өмнөх амьдралд бид Тэнгэрлэг Эцэгийнхээ, сүнсэн хүүхдүүдтэйгээ хийсэн зөвлөгөөнд оролцсон. Уг зөвлөгөөнөөр Тэнгэрлэг Эцэг төлөвлөгөөгөө танилцуулан өмнөх дэлхийн Есүс Христ Аврагч байхаар гэрээ хийсэн юм.

Бид сонгох эрхээ Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөвлөгөөг дагахад ашигласан юм. Бид үргэлжлүүлэн өсч хөгжих боломжтой дэлхийд ирэхээр бэлтгэгдсэн билээ.

Тэнгэрлэг Эцэг ба Есүс Христийг дагасан тэдгээр нь мөнх бус байдалд туршлага хуримтлуулан мөнх амьдрал руу урагшлахын тулд энэ дэлхийд ирэхээр зөвшөөрөгдсөн юм. Бурханы өөр нэгэн сүнсэн хүү Люцифер төлөвлөгөөг эсэргүүцжээ. Тэрээр Сатан болж дагалдагчдынхаа хамтаар тэнгэрээс хөөгдөн, бие махбод болон мөнх бус байдлыг хүлээн авах онцгой эрхээс татгалзжээ.

Холбогдох эшлэл: Иеремиа 1:4–5

Бүтээлт

Есүс Христ Эцэгийнхээ удирдлаган дор тэнгэрүүд мөн газрыг бүтээв. Дэлхий оргүй хоосноос бүтээгдээгүй ба оршин байгаа юмсаас зохион байгуулагдсан юм. Есүс Христ тоолшгүй олон дэлхийнүүдийг бүтээжээ (С ба Г 76:22–24-ийг үзнэ үү).

Дэлхийн бүтээлт нь Бурханы төлөвлөгөөний амин чухал хэсэг нь байлаа. Энэ нь бид бие махбодтой болж, соригдон, бурханлаг зан чанарыг хөгжүүлэх газар юм.

Бид дэлхий дээрх нөөц баялгийг мэргэн ухаанаар, ариг гамтай, талархалтайгаар ашиглах ёстой (С ба Г 78:19-ийг үзнэ үү).

Адам бол дэлхий дээр бүтээгдсэн анхны хүн байлаа. Бурхан өөрийнхөө дүр төрхөөр Адам Ева хоёрыг бүтээсэн. Бурханы дүр төрхөөр хүн төрөлхтөн эрэгтэй эмэгтэй хүмүүс бүтээгдсэн (Эхлэл 1:26–27-г үзнэ үү).

Уналт

Едений цэцэрлэгт, Бурхан Адам Ева хоёрыг сайн мууг мэдүүлэгч модны жимснээс хүртэж болохгүй гэж тушаажээ; хэрвээ идвэл үр дүн нь сүнсний болон биеийн үхэл байлаа. Сүнсний үхэл гэдэг нь Бурханаас тусгаарлагдах юм. Бие махбодын үхэл нь биенээсээ сүнс нь салах юм. Адам Ева хоёр Бурханы тушаалыг зөрчсөн учраас Түүний өмнөөс хөөгдөн, мөнх бус болжээ. Адам, Ева хоёрын зөрчил ба үүний үр дүнд тэдэнд сайн ба мууг мэдүүлж биеийн болон сүнсний үхэл авчирсныг Уналт гэж нэрлэсэн.

Уналтын үр дүнд Адам, Ева хоёр болон тэдний үр удам баяр баясгалан, уй гашууг биеэрээ туулж, сайн ба мууг ялган таньдаг болж, үр хүүхэдтэй болсон юм (2 Нифай 2:25-ыг үзнэ үү). Адам, Ева хоёрын үр удмын хувьд, бид уналтын байдлыг мөнх бус байдалд өвлөн авдаг. Бид Их Эзэнээс тусгаарлагдан мөн биеийн үхэлд харьяалагддаг. Бид амьдралын хүнд хэцүү ба дайсны уруу таталтуудаар соригддог (Мозая 3:19-ийг үзнэ үү).

Уналт бол Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөөний салшгүй хэсэг мөн. Уналт нь хойшоо ухарсан, урагшаа ахисан хоёр талтай юм. Уналт биеийн болон сүнсний үхлийг бий болгосноос гадна дэлхий дээр төрж, сурч, өсч хөгжих боломжийг бидэнд олгосон билээ.

Мөнх бус амьдрал

Мөнх бус амьдрал бол мөнх амьдралд бэлтгэхэд суралцах болон бид өөрсдийнхөө сонголтыг Их Эзэний зарлигийг дагахад ашиглана гэдгээ нотлох цаг хугацаа юм. Мөнх бус амьдралдаа бид бусдыг хайрлаж мөн үйлчлэх ёстой (Мозая 2:17; Моронай 7:45, 47–48-ыг үзнэ үү).

Мөнх бус байдал нь бидний сүнс бие махбодтой нэгдэж, мөнх бус байдлын өмнөх амьдралд боломжгүй байсан тэдгээр арга замуудаар дамжуулан өсч хөгжих боломжуудыг бидэнд олгодог. Бидний бие махбод бол авралын төлөвлөгөөний чухал хэсэг бөгөөд Тэнгэрлэг Эцэгээс өгөгдсөн бэлэг хэмээн бид хүндэтгэх ёстой (1 Коринт 6:19–20-ийг үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Иошуа 24:15; Матай 22:36–39; 2 Нифай 28:7–9; Алма 41:10; С ба Г 58:27

Үхлийн дараах амьдрал

Биднийг үхэх үед бидний сүнс сүнсний дэлхий рүү очин амилуулалтыг хүлээдэг. Зөв шударга хүмүүсийн сүнснүүд аз жаргалын байдал буюу диваажинд хүлээн авагддаг. Олон итгэлтнүүд сайн мэдээг сүнсний шорон дахь тэдгээрт тунхагладаг.

Сүнсний шорон бол үнэнийг мэдэлгүйгээр нас барсан буюу мөнх бус байдалд дуулгаваргүй байсан хүмүүст зориулсан мөнх бус амьдралын дараах ертөнц дэх түр хугацаанд орших газар юм. Сайн мэдээг заалгаж байгаа сүнснүүд наманчлах боломжтой байдаг ба тэдний төлөө ариун сүмүүдэд ёслол гүйцэтгэгдэхэд авралын ёслолуудыг хүлээн авах боломжтой байдаг (1 Петр 4:6-г үзнэ үү). Сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн тэдгээр хүмүүс амилуулалт хүртэл диваажинд байх болно.

Амилуулалт бол бидний сүнс мах, ясан биетэйгээ дахин нэгдэх үйл явц мөн (Лук 24:36–39-ийг үзнэ үү). Амилуулалтын дараа сүнс, бие хоёр хэзээ ч дахин салахгүй бөгөөд бид үхэшгүй болно. Есүс Христ үхлийг ялсан учраас дэлхий дээр төрсөн хүн бүр амилуулагдана (Иов 19:25–26 ; 1 Коринт 15:20–22-ыг үзнэ үү). Зөв шударга хүмүүс ёс бусчуудаас өмнө Эхний амилуулалтаар босч ирнэ.

Амилуулалтын дараа эцсийн шүүлт болох болно. Мөнхийн алдар сууг хүлээн авах эсэхийг тодорхойлохын тулд Есүс Христ хүн бүрийг шүүнэ. Энэхүү шүүлт нь хүн бүр Бурханы зарлигуудад хэр дуулгавартай байснаас хамаарах болно (Илчлэлт 20:12–13, Мозая 4:30-ийг үзнэ үү).

Алдар суугийн гурван хаант улс байдаг (1 Коринт 15:40–42-ыг үзнэ үү). Тэдгээрийн хамгийн дээдэх нь Селестиел хаант улс юм. Есүсийн тухай гэрчлэлдээ хүчтэй, сургаалын зарчмуудад дуулгавартай тэдгээр нь Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христийн оршихуйд селестиел хаант улсад орших болно (С ба Г 131:1–4-ийг үзнэ үү).

Алдар суугийн гурван хаант улсын хоёр дахь нь террестриел хаант улс юм. Есүс Христийн тухай гэрчлэлдээ тууштай биш байсан дэлхийн шударга эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд энэ хаант улсад очих болно.

Телестиел хаант улс бол алдар суугийн гурван хаант улсын хамгийн доод нь юм. Мөнх бус амьдралдаа зөв шударгаас илүү ёс бусыг сонгосон тэдгээр нь энэ хаант улсыг өвлөгчид байх болно. Тэдгээр хүмүүс сүнсний шоронгоос гэтэлгэгдсэн хэвээр дараа өөрсдийн алдар сууг хүлээн авах болно.

Холбогдох эшлэл: Иохан 17:3

4. Есүс Христийн Цагаатгал

Цагаатгах гэдэг нь нүглийн үйлийн төлөө шийтгэл амсч, ингэснээрээ нүглийн үр дагаврыг наманчлагч нүгэлтнээс зайлуулж, Бурханд нийцэх боломжийг түүнд олгодог байна. Есүс Христ бол бүх хүн төрөлхтний төлөө төгс цагаатгал хийж чадах цорын ганц нь байв. Түүний Цагаатгал хүн төрөлхтний нүглүүдийн төлөө Гетсеманийн Цэцэрлэг дэх шаналал, цусны урсалт, загалмай дээрх зовлон болон үхэл, булшнаас амилуулагдсаныг нь багтаадаг (Лук 24:36–39; С ба Г 19:16–19-ийг үзнэ үү). Аврагч өөрийгөө нүглээс хол байлгаж үхлийн дээр хүчтэй байсан учраас Цагаатгалыг гүйцэлдүүлэх боломжтой байв. Мөнх бус эхээсээ Тэрээр үхэх чадварыг өвлөн авсан бол мөнхийн Эцгээсээ амиа эргүүлэн авах хүчийг өвлөн авчээ.

Аврагчийн цагаатгах золиослолоор боломжтой болгогдсон нигүүлслээр бүх хүмүүс амилуулагдаж үхэшгүй байдлыг хүлээн авах болно. Есүс Христийн Цагаатгал нь мөнх амьдралыг хүлээн авах боломжийг бидэнд мөн олгодог (Моронай 7:41-ийг үзнэ үү). Энэ бэлгийг хүлээн аваад Есүс Христийн сайн мэдээгээр бид амьдрах ёстой ба энэ нь Түүнд итгэх итгэл, нүглүүдээ наманчлах, баптисм хүртэх, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах болон эцсээ хүртэл итгэлтэйгээр тэвчихийг багтаадаг (Иохан 3:5-ыг үзнэ үү).

Есүс Христ зөвхөн бидний нүглийн төлөө зовсон төдийгүй уй гашуу, өвчин эмгэг, хүмүүсийн сул доройт Өөртөө авсан нь Цагаатгалын бас нэгэн хэсэг юм (Алма 7:11–13-ыг үзнэ үү). Тэрээр бидний гуниг зовлонг ойлгодог ба Өөрөө үүнийг мэдэрсэн юм. Түүний нигүүлсэл, эсвээс боломж олгогч хүч нь биднийг өөрсдөө хийж чадахгүй үүргүүдээ гүйцэтгэх болон ачаагаа даахад маань хүчирхэгжүүлдэг (Матай 11:28–30; Филиппой 4:13; Ифер 12:27-г үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Иохан 3:5; Үйлс 3:19–21

Есүс Христэд итгэх Итгэл

Итгэл бол “үнэн хийгээд үл харагдах зүйлүүдэд найдах найдвар” юм (Алма 32:21; мөн Ифер 12:6-г үзнэ үү). Энэ бол Бурханы бэлэг.

Итгэл нь хүнийг авралд хөтлөхийн тулд Есүс Христэд төвлөрсөн байх ёстой. Есүс Христэд итгэх итгэлтэй байна гэдэг нь Түүнд болон Түүний хэмжээлшгүй цагаатгал, хүч мөн хайранд нь бүрэн итгэж найдах гэсэн утгатай. Бид бүх зүйлсийг ойлгодоггүй боловч Тэрээр ойлгодог гэдэгт мөн Түүний сургаалуудад итгэх нь үүнд хамаарна (Сургаалт үгс 3:5–6; С ба Г 6:36-г үзнэ үү).

Үйлдэлгүй итгэлээс илүүтэйгээр, бидний амьдралын хэв маяг бидний итгэлийг илэрхийлдэг (Иаков 2:17–18-ыг үзнэ үү). Бид залбирч, судраас судлан, Бурханы тушаалуудыг дагаснаар итгэлээ өсгөж чадна.

Хожмын Үеийн Гэгээнтнүүд Бурхан Эцэг, Ариун Сүнс, санваарын хүч болон сэргээгдсэн сайн мэдээний бусад чухал хэсгүүдэд мөн итгэдэг. Итгэл нь сүнсний болон бие махбодын эдгэрэлтэд, мөн үргэлж урагш давшиж, тулгарсан бэрхшээл, уруу таталтуудыг даван туулах хүч чадалтай байхад бидэнд тусалдаг (2 Нифай 31:19–20-ийг үзнэ үү). Их Эзэн бидний итгэлийн дагуу бидний амьдралд хүчирхэг гайхамшгуудыг үйлдэх болно.

Хүн Есүс Христэд итгэх итгэлээрээ дамжуулан нүглүүдээсээ ангижирч, эцэстээ Бурханы дэргэд орших боломжтой болдог.

Холбогдох эшлэл: Матай 11:28–30

Наманчлал

Наманчлал гэдэг нь бидэнд Бурханы хийгээд дэлхийн мөн өөрсдийн маань талаар шинэ итгэл үнэмшлийг өгдөг оюун ухаан болон зүрх сэтгэлийн өөрчлөлт юм. Мөн энэ нь нүглийг орхиж, уучлалын төлөө Бурхан руу эргэх юм. Наманчлал нь Бурханыг хайрлах хайр ба Түүний тушаалуудыг дагах чин сэтгэлийн хүслээр өдөөгддөг.

Нүгэл биднийг цэвэр ариун биш болгон Тэнгэрлэг Эцэгтээ эргэн очиж амьдрахад зохисгүй болгодог. Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан Тэнгэр дэх Эцэг бидэнд нүглээсээ уучлагдах цор ганц замыг өгсөн юм (Исаиа 1:18-ыг үзнэ үү).

Нүгэл үйлдсэнийхээ төлөө харамсах, Тэнгэрлэг Эцэгт, хэрэв шаардлагатай бол бусад хүмүүст үнэнээ хүлээн гэмших, үйлдсэн нүглийнх нь улмаас хүнд учирсан хохирлыг аль болохоор бүрэн нөхөн төлөхийг хичээх, Бурханы зарлигуудад дуулгавартайгаар амьдрах нь наманчлалд багтана (С ба Г 58:42–43-ыг үзнэ үү).

Холбогдох эшлэлүүд: Исаиа 53:3–5; Иохан 14:6; 2 Нифай 25:23, 26; С ба Г 18:10–11; С ба Г 19:23; С ба Г 76:40–41

5. Эрин үе, Урвалт ба Сэргээлт

Эрин үе

Эрин үе гэдэг нь Их Эзэн сургаал, ёслолууд, санваараа илчилдэг тодорхой цаг хугацаа юм. Энэ нь Их Эзэн энэ дэлхий дээр ариун санваарыг атгадаг, сайн мэдээг

заах болон ёслолуудыг гүйцэтгэх тэнгэрлэг эрх мэдэл бүхий дор хаяж нэг үйлчлэгчтэй байдаг цаг үе юм. Иосеф Смитэд сайн мэдээг илчилснээр эхэлсэн цаг хугацааны бүрэн байдлын эрин үе болох сүүлчийн эрин үед бид амьдарч байна.

Өмнөх эрин үеүд нь Адам, Енох, Ноа, Абрахам, Мосе, Есүс Христ нарын эрин үе байлаа. Үүнээс гадна өөр бусад эрин үеүд байсан нь Нифайчууд болон Жаредчуудынх байв. Эрин үе бүрт Есүс Христийн сайн мэдээ болон авралын төлөвлөгөө илчлэгддэг.

Урвалт

Хүмүүс сайн мэдээний зарчмуудаас нүүр буруулж, санваарын түлхүүрүүдгүй байх үедээ урвалтын байдалд байдаг.

Ерөнхий урвалтын үеүд дэлхийн түүхийн туршид тохиосоор ирсэн билээ. Үүний нэгэн жишээ нь, Аврагч Өөрийн Сүмийг байгуулсны дараа тохиосон Их Урвалт юм (2 Тесалоник 2:1–3-ыг үзнэ үү). Аврагчийн төлөөлөгчид нас барсны дараа сайн мэдээний зарчмуудыг гуйвуулж, сүмийн зохион байгуулалт болон санваарын ёслолуудад эрх мэдэл олгогдоогүй өөрчлөлтийг хийжээ. Энэхүү өргөн цар хүрээтэй ёс бус хэрэг явдлын улмаас Их Эзэн санваарын эрх мэдэл болон түлхүүрүүдийг дэлхийгээс татан авсан юм.

Их Урвалтын үед хүмүүст амьд бошиглогчдын бурханлаг удирдлага чиглүүлэл байсангүй. Олон сүм байгуулагдсан боловч Ариун Сүнсний бэлэг өгөх болон санваарын бусад ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдэл тэдэнд байсангүй. Ариун судруудын зарим хэсэг мушгин гуйвуулагдан эсвэл алга болж, Бурханы тухай үнэн ойлголт хүмүүст байхгүй болсон байлаа.

Тэнгэрлэг Эцэг, Түүний Хайртай Хүү хоёр Иосеф Смит дээр хүрч ирснээр сайн мэдээний бүрэн байдлын сэргээлтийг эхлэх хүртэл энэ урвалт үргэлжилсэн юм.

Сэргээлт

Сэргээлт гэдэг нь газар дэлхий дээрх хүүхдүүдээ Өөрийн сайн мэдээний үнэнүүд болон ёслолуудыг Бурхан дахин сэргээснийг хэлдэг (Үйлс 3:19–21-ийг үзнэ үү).

Сэргээлтийн бэлтгэл болгож, Сэргэн мандалт гэж нэрлэгдэх цаг үед Их Эзэн сайхан сэтгэлт хүмүүсийг төрүүлэн бий болгожээ. Тэд шашны сургаал, зан үйл болон зохион байгуулалтыг Аврагчийн байгуулсан арга зам руу оруулахыг оролдож байв. Гэвч тэдэнд санваарын эрх мэдэл болон сургаалын бүрэн дүүрэн байдал аль нь ч байсангүй.

1820 онд Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр залбирлынх нь хариуд Иосеф Смит дээр хүрч ирснээр

Сэргээлт эхэлсэн юм (Иосеф Смит—Түүх 1:15–20-ийг үзнэ үү). Сэргээлтийн зарим гол үйл явдлууд нь Мормоны Номын орчуулга, Аароны болон Мелкизедек санваарын сэргээлт, 1830 оны 4-р сарын 6-нд Сүмийг зохион байгуулсан явдал байлаа.

1829 оны 5-р сарын 15-нд Иохан Баптист Аароны санваарыг Иосеф Смит, Оливер Каудери хоёрт сэргээв. Төлөөлөгч Петр, Иаков, Иохан гурав Мелкизедек санваар болон хаант улсын түлхүүрүүдийг 1829 онд Иосеф Смит, Оливер Каудери хоёрт сэргээжээ.

Сайн мэдээний бүрэн байдал сэргээгдэж, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм “бүх дэлхийн гадаргуу дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм” болов (С ба Г 1:30). Сүм эцэстээ бүхий л дэлхийг дүүргэж, үүрд орших болно.

Холбогдох эшлэлүүд: Исаиа 29:13–14; Езекиел 37:15–17; Ефес 4:11–14; Иаков 1:5–6

5. Бошиглогчид ба илчлэлт

Бошиглогч бол Бурханыг төлөөлж ярихаар Бурханаар дуудагдсан хүн юм (Амос 3:7-г үзнэ үү). Бошиглогчид Есүс Христийг гэрчилж, Түүний сайн мэдээг заадаг. Тэд Бурханы хүслийг болон үнэн зан байдлыг мэдүүлдэг. Тэд нүглийг буруушаан, үүний үр дагавраас сэрэмжлүүлдэг. Зарим үед тэд ирээдүйн үйл явдлыг бошиглодог (С ба Г 1:37–38-ыг үзнэ үү). Бошиглогчдын заасан олон зүйлсийг судруудаас мэдэж болно. Бид бошиглогчдын үгсийг судалснаар үнэнийг сурч, удирдамж хүлээн авч чадна (2 Нифай 32:3-ыг үзнэ үү).

Бид Сүмийн Ерөнхийлөгчийг бошиглогч, үзмэрч, илчлэгчийн хувьд дэмжин баталдаг бөгөөд тэр бол Сүмийг бүхэлд нь удирдах илчлэлтийг хүлээж авдаг дэлхий дээрх цорын ганц хүн юм. Бид бас Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүдийг бошиглогчид, үзмэрчид, илчлэгчид хэмээн дэмжин баталдаг билээ.

Илчлэлт бол Бурханы хүүхдүүдтэйгээ харилцах харилцаа юм. Их Эзэн Өөрийнхөө хүслийг сүмд илчлэхдээ бошиглогчдоороо дамжуулан ярьдаг. Эртний болон хожмын үеийн бошиглогчдоор өгөгдсөн илчлэлтүүд нь Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сүвд зэрэг судруудад агуулагддаг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч бол өнөөдөр дэлхий дээрх Бурханы бошиглогч юм.

Хувь хүмүүст онцгой хэрэгцээ, үүрэг хариуцлага, асуултуудтай үед нь туслах мөн гэрчлэлээ хүчирхэгжүүлэхэд нь туслах илчлэлтүүдийг тэд хүлээн авч болно. Сүмийн удирдагчид болон гишүүдийн хүлээн

авдаг ихэнх илчлэлтүүд нь бодол, мэдрэмжүүдээр дамжуулан Ариун Сүнснээс ирдэг. Ариун Сүнс бидний оюунд болон зүрх сэтгэлд зөөлөн намуухан дуугаар ярьдаг (С ба Г 8:2–3-ыг үзнэ үү). Илчлэлт нь мөн үзэгдэл, зүүд, тэнгэр элчүүдийн айлчлалаар ирж болно.

Холбогдох эшлэлүүд: Дуулал 119:105; Ефес 4:11–14; 2 Тимот 3:15–17; Иаков 1:5–6; Моронай 10:4–5

Санваар ба санваарын түлхүүрүүд

Санваар бол Бурханы мөнхийн хүч чадал ба эрх мэдэл юм. Бурхан санваараар тэнгэрүүд мөн газрыг бүтээсэн ба үүгээр дамжуулан тэдгээрийг удирддаг билээ. Энэхүү хүчээр Тэрээр хүүхдүүдээ гэтэлгэж, өргөмжлөн “хүмүүнд үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг” улируулан авчирдаг (Мосе1:39).

Бурхан санваарын эрх мэдлийг зөв зохистой сүмийн эрэгтэй гишүүдэд өгдөг ба тэд Түүний хүүхдүүдийн авралын төлөө Түүний нэрээр үйлддэг. Санваарын түлхүүрүүд нь Бурхан газар дэлхий дээрх Өөрийн хаант улсаа удирдан, зохицуулахын тулд хүнд өгсөн хүч буюу тэргүүлэх эрх юм (Матай 16:15–19-ийг үзнэ үү). Эдгээр түлхүүрүүдээр санваар атгагчид сайн мэдээг тунхаглан авралын ёслолуудыг гүйцэтгэх бүрэн эрхтэй болдог. Сүмд үйлчилдэг тэдгээр бүх хүмүүс нь санваарын түлхүүр атгагчийн удирдлаган дор дуудагддаг. Иймээс тэд дуудлагадаа үйлчилж, үүргүүдээ биелүүлэхэд шаардагдах хүчийг хүлээн авдаг.

Холбогдох эшлэл: С ба Г 121:36, 41–42

Аароны санваар

Аароны санваарыг ихэвчлэн бэлтгэл санваар гэж нэрлэдэг. Аароны санваарын албад нь дикон, багш, ахлагч болон бишоп юм. Одоо Сүмийн зохистой эрэгтэй гишүүд 12 настайгаасаа эхлэн Аароны санваар хүлээн авч болно.

Аароны санваар нь “тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний болон баптисмын түлхүүрүүдийг атгадаг” (С ба Г 13:1).

Мелкизедек санваар

Мелкизедек санваар нь илүү дээд, илүү агуу ба сүнсний зүйлүүдийг гүйцэтгэдэг (С ба Г 107:8-ыг үзнэ үү). Энэхүү дээд санваар нь Адамд өгөгдсөн ба Их Эзэн сайн мэдээгээ илчилсэн цаг үеүдэд дэлхий дээр байсаар байгаа билээ.

Энэ нь “Бурханы Хүүгийн жаягийн нэрээр Ариун санваар” хэмээн нэрлэгддэг байв (С ба Г 107:3). Хожим

нь уг санваар бошиглогч Абрахамын үед амьдарч байсан агуу дээд санваартны нэрээр Мелкизедек санваар гэж нэрлэгдсэн юм.

Мелкизедек санваар нь ахлагч, дээд санваартан, патриарх, дал, төлөөлөгч гэсэн албадтай байдаг. Мелкизедек санваартнуудын Ерөнхийлөгч нь сүмийн Ерөнхийлөгч юм.

Холбогдох эшлэл: Ефес 4:11–14

7. Ёслолууд ба Гэрээнүүд

Ёслолууд

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд ёслолууд нь ариун нандин, сүнслэг утга учир бүхий зүй ёсны зан үйл юм. Сүнслэг үнэнүүдийг заахын тулд Бурхан ёслол бүрийг бий болгожээ. Санваарын түлхүүрүүдийг атгагчдын удирдлаган дор санваарын эрх мэдлээр авралын ёслолууд нь гүйцэтгэгддэг. Өргөмжлөлд зайлшгүй чухал зарим ёслолуудыг авралын ёслолууд гэж нэрлэдэг.

Сайн мэдээний авралын анхны ёслол нь эрх мэдэлтэй хэн нэгнээр усанд умбуулан хийгдэх баптисм юм. Баптисм нь хувь хүн сүмийн гишүүн болоход болон селестиел хаант улсад ороход зайлшгүй хэрэгтэй (Иохан 3:5-ыг үзнэ үү).

Баптисм нь Грек хэлний дүрэх буюу умбуулах гэсэн утгатай үг. Усанд умбуулалт нь хүний нүгэлт амьдралын төгсгөл ба түүний Бурханд болон Түүний хүүхдүүдэд үйлчлэх сүнслэг амьдралын дахин төрөлтийн бэлэгдэл юм.

Хүнийг баптисм хүртсэний дараа нэг буюу түүнээс олон Мелкизедек санваартнууд толгой дээр нь гар тавьж түүнийг сүмийн гишүүнээр баталдаг. Гишүүний баталгаа гэж нэрлэгдэх энэхүү ёслолын нэг хэсэг нь Ариун Сүнсний бэлэг өгөх юм.

Ариун Сүнсний бэлэг нь Ариун Сүнсний нөлөөнөөс өөр юм. Баптисмын өмнө хүн Ариун Сүнсийг мэдэрч үүний нөлөөгөөр үнэний тухай гэрчлэлтэй болдог (Моронай 10:4–5-ыг үзнэ үү). Ариун Сүнсний бэлэг хүлээн авсны дараа тэрээр зарлигуудад дуулгавартай байвал Ариун Сүнсийг байнгын хамтрагчаа болгох эрхтэй байдаг.

Бусад авралын ёслолуудад (эрэгтэйчүүдийг) Мелкизедек санваарт томилох, ариун сүмийн хишиг хүртэх, гэрлэлтийг холбох зэрэг нь хамаардаг (С ба Г 131:1–4-ийг үзнэ үү). Санваарын бүх авралын ёслолуудыг гэрээнүүд дагалддаг. Ариун сүмд тэдгээр авралын

ёслолууд нь нас барагсдыг төлөөлөн гүйцэтгэгдэж болно. Төлөөлөх ёслолууд нь зөвхөн сүнсний дэлхий дэх нас барсан хүмүүс нь ёслолуудыг хүлээн зөвшөөрч, холбогдох гэрээнүүдийг хүндэтгэснээр хүчинтэй байдаг.

Мөн өвчтөнийг адислах болон хүүхдэд нэр өгөх зэрэг бусад ёслолууд нь бидний сүнслэг өсөлтөнд чухал байдаг.

Холбогдох эшлэл: Үйлс 2:36–38

Гэрээнүүд

Гэрээ гэдэг нь Бурхан хүн хоёрын хоорондох ариун нандин тохиролцоо юм. Бурхан гэрээний нөхцөлүүдийг өгч харин бид Түүний биднээс хийхийг хүссэн зүйлсийг хийнэ гэж зөвшөөрдөг, тэгээд Бурхан биднийг дуулгавартай байсны хариуд тодорхой адислалуудыг амладаг (С ба Г 82:10-ыг үзнэ үү).

Санваарын бүх авралын ёслолуудыг гэрээнүүд дагалддаг. Бид Их Эзэнтэй баптисмын гэрээ хийдэг ба үүнийгээ ариун ёслолоос хүртсэнээр шинэчилдэг. Мелкизедек санваарыг хүлээн авсан ах нар санваарын гэрээ ба тангарагт ордог. Бид илүү олон гэрээнүүдийг ариун сүмд хийдэг.

Холбогдох эшлэлүүд: Египетээс гарсан нь 19:5–6; Дуулал 24:3–4; 2 Нифай 31:19–20; С ба Г 25:13

8. Гэрлэлт ба Гэр бүл

Гэр бүл нь Бурханаас заяагддаг. Эрэгтэй эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг мөн. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно.

Үр удмаа үлдээх энэхүү ариун хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэж, эхнэр, нөхөр болсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой. Эцэг эхчүүд өнөр өтгөн болж, дэлхийг дүүргэн, хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж, бие бялдрын болон сүнслэг хэрэгцээг нь хангах үүрэгтэй.

Нөхөр, эхнэр хоёр нь бие биеэ хайрлан, халамжлах албан ёсны үүрэг хүлээнэ. Эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга байдлаар тэргүүлэн удирдаж, хэрэгцээг зүйлсээр нь хангах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол үр хүүхдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Эцэг эхчүүд энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ бие биедээ адил тэгш туслах ёстой.

Аз жаргалын бурханлаг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог үргэлжлэх боломжтой болгодог. Дэлхий бүтээгдэж, сайн мэдээ илчлэгдсэнээр гэр бүлүүд бүрэлдэн тогтнож, лацдуулан, үүрд өргөмжлөгдөх боломжтой болсон юм. (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” Ensign, 2010 оны 11-р сар., -өөс хялбаршуулав; мөн LDS.org/topics/family-proclamation-ээс үзнэ үү.)

Холбогдох эшлэлүүд: Эхлэл 2:24; Дуулал 127:3; Малахи 4:5–6; С ба Г 131:1–4

9. Зарлигууд

Зарлигууд нь Бурханы хүн төрөлхтөнд өгдөг хууль болон шаардлагууд юм. Бид Түүний зарлигуудыг дагаснаараа Түүнийг хайрлах хайраа харуулдаг (Иохан 14:15-ыг үз). Зарлигуудыг дагах нь Их Эзэний адислалуудыг авчрах болно (С ба Г 82:10-ыг үзнэ үү).

Хамгийн агуу хоёр тушаал бол “өөрийн Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла. . . . мөн хөршөө өөрийн адил хайрла” (Матай 22:36–39).

Арван зарлиг бол сайн мэдээний чухал хэсэг бөгөөд бидний өргөмжлөлд зайлшгүй шаардлагатай мөнхийн зарчмууд юм (Египетээс гарсан нь 20:3–17-г үзнэ үү). Их Эзэн тэдгээрийг эрт цагт Мосед илчилсэн ба хожмын үеийн илчлэлтүүдэд дахин илэрхийлсэн.

Бусад зарлигууд нь өдөр бүр залбирах (2 Нифай 32:8–9-ийг үзнэ үү), бусдад сайн мэдээг заах (Матай 28:19–20-ийг үзнэ үү), ариун явдлын хуулийг сахих (С ба Г 46:33-ыг үзнэ үү), аравны нэгээ бүрэн төлөх (Малахи 3:8–10-ыг үзнэ үү), мацаг барих (Исаиа 58:6–7-г үзнэ үү), бусдыг уучлах (С ба Г 64:9–11-ийг үзнэ үү), талархлын сүнсстэй байх (С ба Г 78:19-ийг үзнэ үү), мөн мэргэн ухааны үгийг дагах (С ба Г 89:18–21-ийг үзнэ үү) зэрэг юм.

Холбогдох эшлэлүүд: Эхлэл 39:9; Исаиа 58:13–14; 1 Нифай 3:7; Мозая 4:30; Алма 37:35; Алма 39:9; С ба Г 18:15–16; С ба Г 88:124

Энэ сэдвээр илүү их мэдээллийг lds.org руу орж, Teachings, Gospel Topics; эсвэл *Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэл*-ийг үзнэ үү (2004).

